

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны дугаар сарын-
ний өдөр

Улаанбаатар хот

МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагааны зохион байгуулалт, чиг үүрэг, эрх зүйн байдлыг тодорхойлох, төрийн болон бусад төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, харилцахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Мэргэжлийн нэгдсэн холбооны тухай хууль тогтоомж

2.1.Мэргэжлийн нэгдсэн холбооны тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Иргэний хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, энэ хууль, болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулах, салбар, төлөөлөгчийн газар нээх, чиг үүргийг нь тодорхойлох, мэргэжлийн холбооноос төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах зэрэг харилцааг энэ хуулиар зохицуулна.

3.2.Мэргэжлийн нэгдсэн холбоог улсын бүртгэлд бүртгэхтэй холбоотой харилцааг Хуулийн улсын бүртгэлийн тухай хуулиар зохицуулна.

3.3.Мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагааны талаар энэ хуулиар зохицуулаагүй харилцааг Төрийн бус байгууллагын тухай хуулиар зохицуулна.

3.4.Тусгайлсан хуулиар төрийн бус байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа бол энэ хууль үйлчлэхгүй.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёо

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“мэргэжлийн нэгдсэн холбоо” гэж тодорхой салбарыг хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлэх, үр өгөөжийг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийг

мэргэжлийн зөвлөмж, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, салбарт төрийн оролцоог багасган захиргааны чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх зорилгоор ижил төстэй мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, ашгийн төлөө хуулийн этгээд, иргэн хамтран нэгдсэн бодлого, хамтын хяналт, зохион байгуулалттайгаар байгуулсан нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг;

ХОЁРДУГААР БҮЛЭГ МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ ТОГТОЛЦОО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЧИГ ҮҮРЭГ

5 дугаар зүйл. Мэргэжлийн нэгдсэн холбоонд тавигдах шаардлага

5.1. Мэргэжлийн нэгдсэн холбоог Төрийн бус байгууллагын тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу, тодорхой салбарт хамаарах үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага аж ахуйн нэгж, болон иргэн хамтран үүсгэн байгуулна.

5.2.Тухайн салбарт мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад дараах шаардлага тавигдана:

5.2.1.гишүүд нь тухайн салбарт тасралтгүй 3-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх

5.2.2.гишүүн төрийн бус байгууллага төрийн байгууллагатай гэрээ байгуулж ажил гүйцэтгэж байсан туршлагатай байх

5.2.3.олон улсын байгууллагатай хамтран ажилласан туршлагатай байх

5.2.4.дунд болон урт хугацааны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөтэй байх

5.3.Монгол Улсад тухайн салбарын нэг мэргэжлийн нэгдсэн холбоо ажиллана.

5.4.Тухайн салбарын мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүдийн дийлэнх олонх нь салбарын мэргэшсэн төрийн бус байгууллага, мэргэшсэн хувь хүн байна.

5.4.Мэргэжлийн нэгдсэн холбоо нь орон нутагт болон гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээж болно.

5.5.Мэргэжлийн нэгдсэн холбооны орон нутгийн салбар, төлөөлөгчийн газрын эрх хэмжээг түүний дүрмээр зохицуулна.

6 дугаар зүйл. Мэргэжлийн нэгдсэн холбооны нэр

6.1.Мэргэжлийн нэгдсэн холбооны нэр нь салбарын онцлогийг илэрхийлсэн оноосон нэр болон “Мэргэжлийн нэгдсэн холбоо” гэсэн дэлгэрэнгүй тэмдэглэгээ, эсхүл “МНХ” гэсэн товчилсон тэмдэглэгээнээс бүрдэнэ.

6.2.Энэ хуулийн 5.1-д зааснаас бусад төрийн бус байгууллага өөрийн оноосон нэртэй хамт “Мэргэжлийн нэгдсэн холбоо” эсхүл “МНХ” гэсэн тэмдэглэгээ хэрэглэхийг хориглоно.

7 дугаар зүйл. Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүнчлэл

7.1.Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүн нь салбарт хамаарах мэргэжлийн чиглэлээр байгуулагдсан төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, мэргэшсэн хувь хүн байна.

7.2.Хувь хүн мэргэжлийн нэгдсэн холбоонд гишүүнээр элсэж болно.

7.3.Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүн иргэн бусадтай сайн дураараа эвлэлдэн нэгдэж төрийн бус байгууллага байгуулж болно.

7.4.Мэргэжлийн нэгдсэн холбооны гишүүн нь дараах шаардлагыг хангасан байна:

7.4.1.төрийн бус байгууллага нь салбартаа 3-аас доошгүй жил идэвхтэй үйл ажиллагаа явуулсан, нийтэд үйлчилдэг байх;

7.4.2.хувь хүн нь тухайн салбарын магистраас дээш боловсролын зэрэгтэй, эрдэмтэн, судлаач байх;

7.4.3.аж ахуйн нэгж нь тухайн салбарт 10-аас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан, ашгийн төлөө хуулийн этгээд байх.

8 дугаар зүйл. Мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагааг зөвшөөрөх

8.1.Мэргэжлийн нэгдсэн холбоо нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэхээс өмнө үйл ажиллагаа явуулах хүсэлтээ тухайн салбарын төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

8.2.Мэргэжлийн нэгдсэн холбоо үйл ажиллагаа явуулах хүсэлтдээ эн хуулийн 5.2-т заасан баримт болон гишүүнчлэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргана.

8.3.Хүсэлт хүлээн авсан төрийн захиргааны төв байгууллага баримт бичгийн бүрдлийг хянан үзэж, сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

8.4.Салбарын төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрөлгүйгээр мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагаа эрхлэх, оноосон нэрийн ард энэ хуулийн 6.1-д заасан тэмдэглэгээ хэрэглэхийг хориглоно.

8.5.Салбарын төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрөлгүй бол мэргэжлийн нэгдсэн холбоог хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэхгүй.

9 дүгээр зүйл. Мэргэжлийн нэгдсэн холбооны чиг үүрэг

9.1. Мэргэжлийн нэгдсэн холбоо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.1.1.салбарт хамаарах асуудлаар мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө үзүүлэх;

9.1.2.гишүүдийн ёс зүйн болон үйл ажиллагааны дүрэм баталж, мөрдүүлэх;

9.1.3.төрийн байгууллагын зарим чиг үүргийг нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;

9.1.4.салбарт шинэ технологи нэвтрүүлэх, хөгжлийг дэмжих судалгаа хийж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах.

10 дугаар зүйл. Мэргэжлийн нэгдсэн холбооны зохион байгуулалт

10.1.Мэргэжлийн нэгдсэн холбоо нь үйл ажиллагааны тайлангаа жил бүр салбарын аж ахуйн нэгж, шинжлэх ухааны байгууллага, иргэд, олон нийтэд танилцуулна.

10.2.Мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагааны талаарх мэдээллийг Мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу сонирхсон этгээдэд нээлттэй байлгана.

10.3.Мэргэжлийн нэгдсэн холбоо нь салбарын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор богино, дунд, урт хугацааны хамтын ажиллагааны гэрээг салбарын төр захиргааны төв байгууллагатай байгуулж, хагас, бүтэн жил, 4 жилээр гэрээний үүргийн биелэлтийг дүгнэж ажиллана.

11 дүгээр зүйл. Мэргэжлийн нэгдсэн холбооны их хурал

11.1.Мэргэжлийн нэгдсэн холбооны өөрөө удирдах ёсны эрх барих дээд байгууллага нь гишүүдийн их хурал (Цаашид “их хурал”) байна.

11.2.Их хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.2.1.мэргэжлийн нэгдсэн холбооны дүрэм батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

11.2.2.мэргэжлийн нэгдсэн холбооны Ерөнхийлөгчийг сонгох, чөлөөлөх;

11.2.3.мэргэжлийн нэгдсэн холбооны зөвлөлийн гишүүнийг батламжлах, чөлөөлөх;

11.2.4.мэргэжлийн нэгдсэн холбооны зөвлөлийн үйл ажиллагааны тайлан сонсох, зөвлөмж өгөх;

11.2.5.мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмээр тогтоосон бусад бүрэн эрх.

11.3.Мэргэжлийн нэгдсэн холбооны их хурлын ээлжит хуралдаан жилд нэг удаа хуралдах бөгөөд их хурал хуралдаан даргалагчаа сонгож, хуралдааны дэгээ тогтооно.

11.4.Их хуралд нийт төлөөлөгчдийн олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно.

11.5.Их хуралд оролцох төлөөлөгчдийг сонгох журмыг мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмээр тогтооно.

11.6.Их хурлын тов болон хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг хуралдаан эхлэхээс 21 хоногийн өмнө мэргэжлийн нэгдсэн холбооны Ерөнхийлөгч хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

11.7.Их хурлаар хэлэлцсэн асуудлаар оролцсон төлөөлөгчдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэж, хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргана.

12 дугаар зүйл. Мэргэжлийн нэгдсэн холбооны Ерөнхийлөгч, түүний бүрэн эрх

12.1.Мэргэжлийн нэгдсэн холбооны Ерөнхийлөгч нь тухайн салбарт мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, мэргэжлийн нэр хүнд, ёс зүйн хувьд үлгэр дуурайлал үзүүлэгч, салбарын мэргэжилтнүүдийн мэргэжлийн байр суурийг бодлогын хувьд илэрхийлэгч байна.

12.2.Мэргэжлийн нэгдсэн холбооны Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа гурван жил байх бөгөөд түүнийг нэг удаа улируулан сонгоно.

12.3.Мэргэжлийн нэгдсэн холбооны Ерөнхийлөгч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.3.1.их хурлын тов тогтоох, хуралдуулах;

12.3.2.мэргэжлийн нэгдсэн холбооны зөвлөлийн хуралдааныг даргалах;

12.3.3.мэргэжлийн нэгдсэн холбоог гадаад, дотоодод төлөөлөх;

12.3.4.энэ хуулиар болон мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмээр олгосон бусад бүрэн эрх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХАМТЫН АЖИЛЛАГАА

13 дугаар зүйл. Мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагааг дэмжих талаар төрийн байгууллагын чиг үүрэг

13.1.Төвлөрлийг сааруулах, чиг үүрэг, эрх мэдлийг оновчтой хуваарилах, шийдвэр гаргалтад мэргэжлийн байгууллагын оролцоог дэмжих зорилгоор хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрт мэргэжлийн нэгдсэн холбооны чиг үүргийг тусгаж, эрх зүйн орчин бүрдүүлнэ.

13.2.Төрийн байгууллагаас хууль тогтоомжид заасан гүйцэтгэх, зохион байгуулах зарим чиг үүргээ энэ хуулийн дагуу байгуулагдсан мэргэжлийн нэгдсэн холбоогоор нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

13.3.Гадаад улсын байгууллагатай хамтран ажиллахаар байгуулсан гэрээг салбарын хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлэхэд тодорхой ажил үйлчилгээг гүйцэтгүүлэхээр мэргэжлийн нэгдсэн холбоог сонгож болно.

13.4.Хууль тогтоомж, бусад шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсэг, мэргэжлийн болон зөвлөх чиг үүрэг бүхий зөвлөл, хорооны бүрэлдэхүүнд мэргэжлийн нэгдсэн холбооны төлөөллийг оролцуулна.

14 дүгээр зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбоо төрийн байгууллагатай хамтран ажиллах

14.1.Мэргэжлийн нэгдсэн холбоо нь энэ хууль болон дүрэмдээ заасан зорилго, чиг үүргээ хэрэгжүүлэхдээ төрийн байгууллагатай дараахь чиглэлээр хамтран ажиллана:

14.1.1.салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх саналаа төрийн байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг хамтран зохион байгуулах;

14.1.2.хууль тогтоомжийн төсөл боловсруулахад мэргэжлийн зөвлөгөө, арга зүйн зөвлөмжөөр хангаж, дэмжлэг үзүүлэх;

14.1.3.Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заасан бодлогын баримт бичгийг боловсруулахад мэргэжлийн зөвлөгөө, арга зүйн зөвлөмжөөр хангаж, дэмжлэг үзүүлэх;

14.1.4.захиргааны хэм хэмжээний акт боловсруулахад батлах эрх бүхий байгууллага албан тушаалтантай хамтран ажиллах, төсөл боловсруулж хүргүүлэх;

14.1.5.салбарын бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний норм, норматив, стандарт, дүрэм, журмыг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

14.1.6.салбарын хүний нөөцийг чадавхжуулах, мэргэжлийн зэрэг дэв, итгэмжлэл олгох болон мэргэшүүлэх сургалт зохион байгуулах чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэх;

14.1.7.салбарын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, олон нийтийг мэдээллээр хангах чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэх;

14.1.8.салбарын дотоод зах зээлийг хамгаалах, экспортыг нэмэгдүүлэх чиглэлийн татвар, зээлийн болон бусад дэмжлэг, урамшууллын талаар санал боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

14.1.9.салбарын хэмжээнд байгаль орчныг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах, нөхөн сэргээх чиглэлийн бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

14.1.10.дотоод, гадаадад төрөлжсөн үзэсгэлэн, яармаг, хурал, зөвлөгөөн зохион байгуулах;

14.1.11.хуульд болон гэрээнд заасан бусад.

14.2.Мэргэжлийн нэгдсэн холбоо нь хууль болон гэрээнд зааснаас гадна үйл ажиллагааны тайлангаа жил бүрийн 12 дугаар сард багтаан салбарынхаа төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

15 дугаар зүйл. Мэргэжлийн нэгдсэн холбоо бусад байгууллагатай хамтран ажиллах

15.1.Мэргэжлийн нэгдсэн холбоо нь энэ хуульд заасан зорилго, чиг үүргээ хэрэгжүүлэхдээ бусад байгууллага, аж ахуйн нэгжтэй дараах чиглэлээр хамтран ажиллана:

15.1.1.салбарын техник, технологи, инноваци, менежмент, шинэчлэл, стандартыг салбарынхаа онцлогт тохируулан үе шаттайгаар нутагшуулахад мэргэжлийг зөвлөмжөөр хангах, хамтран ажиллах;

15.1.2.салбарын бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний өөрийн өртөг, зардлын тооцоолол хийх, тарифын жишиг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

15.1.3.үйл ажиллагааг нь өргөжүүлэх, бизнес хөгжүүлэлтийг дэмжих болон бусад мэргэжлийн зөвлөгөө, арга зүйн зөвлөмжөөр хангах, сургалт сурталчилгаа зохион байгуулах;

15.1.4.хууль болон мэргэжлийн нэгдсэн холбооны дүрэмд заасан бусад.

16 дугаар зүйл. Мэргэжлийн нэгдсэн холбоог итгэмжлэх

16.1.Төрийн захиргааны төв байгууллага салбартаа үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн нэгдсэн холбоог байгуулагдсанаас нь хойш 5 жил тутамд итгэмжилнэ.

16.2.Мэргэжлийн нэгдсэн холбоонд итгэмжлэл олгох, хүчингүй болгох, сунгах журмыг Засгийн газар батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

17 дугаар зүйл. Мэргэжлийн нэгдсэн холбооны санхүүжилт, түүний эх үүсвэр

17.1.Мэргэжлийн нэгдсэн холбооны орлого нь Төрийн бус байгууллагын тухай хуулийн 19 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

17.1.1.төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэхээр, төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олгосон хөрөнгө;

17.1.2.өөрийн өмчлөлийн эд хөрөнгийг худалдах болон түрээслүүлснээс олсон орлого;

17.1.3.мэргэжлийн нэгдсэн холбооны мөнгөн хөрөнгийг банк, банк бус байгууллагад хадгалуулсны хүүгийн орлого.

17.2.Төсвийн хөрөнгөөр төрийн байгууллагын захиалгаар эсхүл байгууллага, хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгэснээс бусад мэргэжлийн нэгдсэн холбооны үйл ажиллагааны үр дүнд бий болсон дэвшилтэт технологи, мэдээллийн сан, оновчтой менежмент нь холбооны өмч байна.

18 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

18.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

19 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

19.1.Энэ хуулийг 2018 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ